**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

# Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/134/НА-СТА-ОНӨТҮГ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа<br>Утас: 99108763, Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 543

танай ______________-ны № _______________-т

"УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Ц.БАНЗРАГЧ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн,мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨААТҮГ нь орон нутгийн төсвөөс 100 хувь санхүүждэг, төсөвт байгууллагын статустай хуулийн этгээд юм. Хотын нийтийн үйлчилгээ үзүүлдэг бүх байгууллага, аж ахуйн нэгжүүдийн диспетчер, жижүүр, шуурхай үйлчилгээний баг, бригадын ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант онд төвийн 310005 дугаарын утсаар 37555 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс шууд зөвлөгөө өгсөн 20117, бүрэлдэхүүн байгууллагуудаас ирсэн хүсэлт 14639 байна.

**Аудитын гол асуудал**

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан багаж техник хэрэгсэл, сэлбэгийн нөөц худалдан авах тендер шалгаруулалтаар 61,790.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, программын лицензийг хүлээн авсан байна.

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026 Word ... 14250535

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.2 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026Dugnelt.docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 630,460,594.53 | 624,567,990.78 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 11,320,615.00 | 6,804,618.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 11,320,615.00 | 6,804,618.00 |
| 3121 | Төгрөг | 11,320,615.00 | 6,804,618.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 11,320,615.00 | 6,804,618.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 619,139,979.53 | 617,763,372.78 |
| 351 | Түүхий эд материал | 1,110,587.50 | 698,100.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,027,700.00 | 698,100.00 |
| 35130 | Эм боох материал | 82,887.50 | - |
| 354 | Хангамжийн материал | 618,029,392.03 | 617,065,272.78 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,182,634.00 | 3,004,924.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,555,740.00 | 3,429,240.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 188,953,836.69 | 190,513,836.69 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,167,524.05 | 1,263,824.80 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 420,169,657.29 | 418,853,447.29 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 237,921,248.98 | 202,136,593.12 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 237,921,248.98 | 202,136,593.12 |
| 392 | Биет хөрөнгө | 205,862,539.32 | 161,320,158.26 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 48,500,000.00 | 48,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (48,500,000.00) | (48,500,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,600,547,764.27 | 1,568,946,274.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,404,179,150.24) | (1,416,772,875.27) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 95,853,522.00 | 96,733,522.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (93,330,846.72) | (93,843,013.32) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,150,000.00 | 7,150,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (178,749.99) | (893,749.95) |
| 393 | Биет бус хөрөнгө | 32,058,709.66 | 40,816,434.86 |
| 39301 | Програм хангамж | 847,949,739.00 | 871,660,539.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (815,891,029.34) | (830,844,104.14) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 868,381,843.51 | 826,704,583.90 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 11,320,615.00 | 9,309,352.50 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 11,320,615.00 | 9,309,352.50 |
| 413 | Өглөг | 11,320,615.00 | 9,309,352.50 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 2,504,734.50 |
| 4136 | Бусад өглөг | 11,320,615.00 | 6,804,618.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 11,320,615.00 | 6,804,618.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 857,061,228.51 | 817,395,231.40 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 857,061,228.51 | 817,395,231.40 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 857,061,228.51 | 817,395,231.40 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 857,061,228.51 | 857,061,228.51 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (39,665,997.11) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 868,381,843.51 | 826,704,583.90 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,081,146,324.56** | **1,233,752,919.21** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,081,146,324.56** | **1,233,752,919.21** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **35,297,500.00** | **28,200,400.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 35,262,500.00 | 28,165,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,000.00 | 35,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,045,848,824.56** | **1,205,552,519.21** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,045,848,824.56 | 1,205,552,519.21 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,157,487,540.63** | **1,272,529,456.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,157,487,540.63** | **1,272,529,456.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,111,876,754.63** | **1,268,738,456.32** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **620,208,672.21** | **862,148,937.48** |
| 210101 | Үндсэн цалин | 285,662,831.29 | 358,558,305.27 |
| 210102 | Нэмэгдэл | 175,441,625.30 | 259,871,323.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 98,471,734.00 | 201,189,412.59 |
| 210104 | Урамшуулал | 60,632,481.62 | 42,529,896.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **102,943,539.64** | **130,896,810.50** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,402,582.24 | 69,268,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,582,729.78 | 13,931,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,353,627.76 | 5,115,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,327,699.86 | 24,290,634.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,276,900.00 | 18,290,876.38 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **47,323,187.93** | **69,531,565.87** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 811,975.66 | 11,491,171.53 |
| 210304 | Байрны түрээс | 46,511,212.27 | 58,040,394.34 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,516,625.13 | 27,032,652.61 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,780,416.00 | 2,560,801.64 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,463,001.57 | 7,470,929.25 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,940,607.56 | 2,880,827.22 |
| **210405** | **Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал** | **660,000.00** | **-** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,672,600.00 | 14,120,094.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 93,154,361.22 | 33,663,080.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,302,000.00 | 4,499,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 23,180.00 |
| 210604 | Урсгал засвар | 91,852,361.22 | 29,140,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **110,478,840.00** | **47,847,914.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 62,495,340.00 | 18,800,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 577,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 73,500.00 | 969,312.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 42,300,000.00 | 22,942,832.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 102,770.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **117,251,528.50** | **97,617,495.86** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 640,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 340,000.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 116,911,528.50 | 96,977,495.86 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **45,610,786.00** | **3,791,000.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 45,575,786.00 | 3,756,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 33,665,786.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,910,000.00 | 3,756,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **35,000.00** | **35,000.00** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(76,341,216.07)** | **(38,776,537.11)** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 889,460.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 889,460.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-** | **(889,460.00)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(76,341,216.07)** | **(39,665,997.11)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,081,332,324.56** | **1,236,813,034.21** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **186,000.00** | **3,060,115.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **186,000.00** | **3,060,115.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 186,000.00 | 3,060,115.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 186,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 3,060,115.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,081,146,324.56** | **1,233,752,919.21** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **35,297,500.00** | **28,200,400.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 35,262,500.00 | 28,165,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,000.00 | 35,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,045,848,824.56** | **1,205,552,519.21** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,045,848,824.56 | 1,205,552,519.21 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,043,954,962.56** | **1,171,670,619.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,043,954,962.56** | **1,171,670,619.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **998,344,176.56** | **1,166,138,719.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **630,105,404.07** | **880,140,290.30** |
| 210101 | Үндсэн цалин | 315,631,894.99 | 384,896,439.59 |
| 210102 | Нэмэгдэл | 155,369,293.46 | 245,871,344.01 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 108,740,000.00 | 186,340,000.00 |
| 210104 | Урамшуулал | 50,364,215.62 | 63,032,506.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **93,046,807.78** | **110,394,200.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,842,443.24 | 75,068,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,288,964.54 | 8,831,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,110,800.00 | 4,415,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,527,700.00 | 4,415,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,276,900.00 | 17,663,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **47,498,187.93** | **70,072,317.51** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 811,975.66 | 11,491,171.53 |
| 210304 | Байрны түрээс | 46,686,212.27 | 58,581,145.98 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,925,777.23** | **11,713,167.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,494,230.00 | 1,297,470.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,020,000.00 | 5,880,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,929,347.23 | 2,887,350.40 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 660,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,822,200.00 | 1,648,347.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **4,320,000.00** | **-** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,320,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **96,629,159.55** | **44,933,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 96,629,159.55 | 44,933,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **110,478,840.00** | **47,745,144.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 62,495,340.00 | 18,800,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 5,975,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 577,000.00 | 596,412.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 73,500.00 | 372,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 42,300,000.00 | 21,967,832.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **340,000.00** | **1,140,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 1,140,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 340,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **45,610,786.00** | **5,531,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **45,575,786.00** | **5,496,900.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 33,665,786.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,910,000.00 | 5,496,900.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 35,000.00 | 35,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **37,377,362.00** | **65,142,415.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **32,730,000.00** | **69,658,412.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **32,730,000.00** | **69,658,412.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **32,730,000.00** | **69,658,412.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 7,576,112.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 32,730,000.00 | 62,082,300.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(32,730,000.00)** | **(69,658,412.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **4,647,362.00** | **(4,515,997.00)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **6,673,253.00** | **11,320,615.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **11,320,615.00** | **6,804,618.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **933,402,444.58** | **933,402,444.58** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 933,402,444.58 | 933,402,444.58 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (76,341,216.07) | (76,341,216.07) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **857,061,228.51** | **857,061,228.51** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 857,061,228.51 | 857,061,228.51 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (39,665,997.11) | (39,665,997.11) |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **817,395,231.40** | **817,395,231.40** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,299,291,900.00** | **1,205,552,519.21** | **93,739,380.79** | **92.8** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,299,291,900.00** | **1,205,552,519.21** | **93,739,380.79** | **92.8** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,299,291,900.00 | 1,205,552,519.21 | 93,739,380.79 | 92.8 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,299,291,900.00** | **1,205,552,519.21** | **93,739,380.79** | **92.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,299,291,900.00** | **1,205,552,519.21** | **93,739,380.79** | **92.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,287,291,900.00** | **1,200,055,619.21** | **87,236,280.79** | **93.2** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **903,952,600.00** | **880,140,290.30** | **23,812,309.70** | **97.4** |
| 210101 | Үндсэн цалин | 403,550,000.00 | 384,896,439.59 | 18,653,560.41 | 95.4 |
| 210102 | Нэмэгдэл | 249,137,600.00 | 245,871,344.01 | 3,266,255.99 | 98.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 186,340,000.00 | 186,340,000.00 | - | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 64,925,000.00 | 63,032,506.70 | 1,892,493.30 | 97.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **115,494,200.00** | **110,394,200.00** | **5,100,000.00** | **95.6** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,168,000.00 | 75,068,000.00 | 5,100,000.00 | 93.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,831,500.00 | 8,831,500.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,415,800.00 | 4,415,800.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,415,800.00 | 4,415,800.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,663,100.00 | 17,663,100.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **74,870,700.00** | **70,072,317.51** | **4,798,382.49** | **93.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,268,700.00 | 11,491,171.53 | 777,528.47 | 93.7 |
| 210304 | Байрны түрээс | 62,602,000.00 | 58,581,145.98 | 4,020,854.02 | 93.6 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **19,040,900.00** | **11,713,167.40** | **7,327,732.60** | **61.5** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,496,800.00 | 1,297,470.00 | 199,330.00 | 86.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,106,300.00 | 5,880,000.00 | 1,226,300.00 | 82.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,277,800.00 | 2,887,350.40 | 390,449.60 | 88.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,180,000.00 | - | 2,180,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,980,000.00 | 1,648,347.00 | 3,331,653.00 | 33.1 |
| **2105** | **Нормативт зардал** | **4,600,000.00** | **-** | **4,600,000.00** | **-** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,600,000.00 | - | 4,600,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **104,333,500.00** | **79,990,500.00** | **24,343,000.00** | **76.7** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 62,082,300.00 | 61,790,500.00 | 291,800.00 | 99.5 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,251,200.00 | 291,800.00 | 959,400.00 | 23.3 |
| 210604 | Урсгал засвар | 41,000,000.00 | 17,908,200.00 | 23,091,800.00 | 43.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **64,150,000.00** | **47,745,144.00** | **16,404,856.00** | **74.4** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил | 28,000,000.00 | 18,800,000.00 | 9,200,000.00 | 67.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний төлбөр хураамж | | | | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,975,000.00 | 5,975,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 674,000.00 | 596,412.00 | 77,588.00 | 88.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 373,500.00 | 372,900.00 | 600.00 | 99.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,000.00 | 33,000.00 | 7,000.00 | 82.5 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 29,087,500.00 | 21,967,832.00 | 7,119,668.00 | 75.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **850,000.00** | **-** | **850,000.00** | **-** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - | - | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 850,000.00 | - | 850,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12,000,000.00 | **5,496,900.00** | **6,503,100.00** | **45.8** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 12,000,000.00 | 5,496,900.00 | 6,503,100.00 | 45.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,000,000.00 | 5,496,900.00 | 6,503,100.00 | 45.8 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **22** | **20** | **2** | **90.9** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 21 | 19 | 2 | 90.5 |

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт санхүүжилтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **28,200,400.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 28,200,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 28,165,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 35,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **28,200,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **28,200,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 28,165,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 27,025,400.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 27,025,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 1,140,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 1,140,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 35,000.00 |

***Илрүүлэлт:***

Тайлант хугацаанд төсвийн шууд захирагч 2,819,369.5 мянган төгрөгийн 171 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 165 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 10 гүйлгээний 56,500.0 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.1.1 ”*тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор*”, 6.4.5 “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

> *Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулж хэвших зөвлөмж өгөв.

***Илрүүлэлт:*** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 682 ширхэг 2,123,047.0 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “*Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам*"-ын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох“ 7.1-д *“төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ*” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

***Илрүүлэлт:*** Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна*", 8.1.5 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-т "*Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана*" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж*:* Санхүүгийн тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан тодруулга тайланг бэлтгэж байх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 682 ширхэг 2,123,047.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **2** | **-** | | | **-** | **-** | **2** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөг/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл огт байршуулаагүй. 12 мэдээлэл хугацаа хоцроосон. Өмнөх аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй. | 1 | - | - | - | | | 1 | 56,500.0 |
| **Дүн** | **1** | 56,500.0 | | | | | 1 | 56,500.0 |